



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/МЧ

Булган сум

“Таван аваргын нэрэмжит” бөхийн барилдаан
зохион байгуулалтын зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Арван долдугаар жарны Сүрээр дарагч “Гал морь жил”-ийн сар шинийн баярыг тохиолдуулан “Таван аваргын нэрэмжит” улс, аймгийн цолтой 128 бөхийн барилдааныг Улаанбаатар хотод 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 12,420,000 (арван хоёр сая дөрвөн зуун хорин мянга) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх” хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010186

Аймгийн Засаг даргын 2026 оны
02 дугаар сарын 24-ны/ний өдрийн
А/АМ дугаар захирамжийн хавсралт

**“ТАВАН АВАРГЫН НЭРЭМЖИТ” УЛС, АЙМГИЙН ЦОЛТОЙ 128 БӨХИЙН
БАРИЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРДАЛ**

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	Бөхийн өргөө хүндэтгэлийн ширээ	1	1,000,000	1,000,000
2	Цагаан идээ ааруул	12	35,000	420,000
3	Арын өрөөний тавгийн идээ (Тавгийн идээ, өрөм, бяслаг, чихэр)	1	1,000,000	1,000,000
4	Айраг	1000	10,000	10,000,000
	Нийт дүн			12,420,000

--o00o--